БАТЛАВ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА

Б.ЦЭРЭН

2026 оны 1 сарын 28 өдөр

БАГЦ 1. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН АРЧИЛГАА, НӨХӨН ТАРИЛТЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2026 оны 01 дүгээр сарын 27 өдөр №01/01 Улаанбаатар хот

Ажлын цар хэмжээ:

Хан-Уул дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, талбайн ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтын ажлыг гэрээт хугацаанд агро технологийн горимын дагуу ногоон байгууламжийн арчилгаанд тавигдах, стандарт шаардлагыг хангаж, гүйцэтгэл, үр дүнг тайлагнаж ажиллана.

Ажлыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам стандартын зааврын дагуу хийж гүйцэтгэнэ.

1	Ажлын нэр	Багц 1. Хан-Уул дүүргийн нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн арчилгаа, нөхөн тарилтын ажил (1, 15 дугаар хороо)
2	Үндэслэл, хэрэгцээ шаардлага	- Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр; - Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 17 дугаар тогтоол; - Хан-Уул дүүргийн Засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/17 дугаар захирамж;
3	Байршил, талбайн Хэмжээ	- Шинэ Хан-Уул цэцэрлэгт хүрээлэн, 22-р байрны зүүн тал (Хан-Уул дүүрэг, 1-р хороо)- 20634 м.кв - Махатма Гандийн гудамж (Хан-Уул дүүрэг, 15-р хороо)- 6740 м.кв - Төв цэнгэлдэх хүрээлэн (Хан-Уул дүүрэг, 15-р хороо)- 33606 м.кв Нийт – 60980 м.кв (зүлэгт талбай – 49774 м.кв, хатуу хучилттай талбай – 11206 м.кв)
4	Гүйцэтгэх хугацаа	- Ажил гүйцэтгэх хугацаа нь 3 хүртэл жил байх бөгөөд захиалагч гүйцэтгэгч нарын хооронд байгуулах гэрээгээр зохицуулна.
5	Захиалагч	- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
6	Гүйцэтгэх байгууллага	Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх (Мод үржүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээх) гэрчилгээтэй байна. **Нэг. Инженер техникийн ажилтны бүрэлдэхүүн:** 1. Инженер - Ойн чиглэлийн (ойн инженер, ойн аж ахуйн инженер, ой зүйч, ой судлал) эсвэл ландшафтын архитектур, агроном мэргэжилтэй, ажлын туршлагатай, үндсэн ажилтан байх – 1 хүн 2. Бичиг хэргийн ажилтан байх-1 хүн 3. Дотоод хяналт хариуцсан ажилтан байх-1 хүн 4. Цэцэрлэгч – 3-оос доошгүй хүн 5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хариуцах мэргэжилтэн – 1 хүн 6. Зам талбайн үйлчлэгч – 2 хүн **Хоёр. Машин, тоног төхөөрөмж** 7. Усалгааны машин (5 тн-оос дээш) – 2 8. Хог тээвэрлэх машин (2 тн-оос дээш) -2 9. Сийрүүлэгч – 4-оос доошгүй 10. Үүрдэг хадуур – 5-оос доошгүй 11. Зүлэг тэгшлэгч машин – 4-оос доошгүй

		12. Нүх ухагч – 2 13. Мөчир огтлогч – 4-оос доошгүй 14. Хэлбэржүүлэгч хөрөө – 4-оос доошгүй 15. Хэлбэржүүлэгч хайч - 4-оос доошгүй 16. Хор цацагч – 2 17. Цэцэрлэгчийн бусад шаардлагатай багаж хэрэгсэл Гэрээг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн машин, тээврийн хэрэгсэл нь замын хөдөлгөөний дүрмийг хангасан таних тэмдэгтэй байх, харанхуй үед болон үзэгдэлт хангалтгүй нөхцөлд тээврийн хэрэгслийн таних тэмдгийн өнгө, дүрслэл нь замын хөдөлгөөнд оролцогчдод тод харагдаж байх үүднээс гэрэл ойлгох шинж чанар бүхий гадаргуутай, эсхүл гадна талаасаа буюу дотроосоо гэрэлтүүлэгтэй байвал зохино.
7	Агро технологийн ажилбарууд	1. Ногоон байгууламжийн үзлэг хийх 2. Мод, сөөгөнд цэвэрлэгээний огтлол хийх 3. Мод, бутны титэм угаах 4. Мод, сөөгөнд залуужуулах огтлол хийх 5. Мод, сөөг хэлбэржүүлэх 6. Зүлэгт талбайг самнах 7. Мод, бут, сөөг, зүлэгт талбайг услах 8. Ургамлан хашлага тайрах, хэлбэржүүлэх 9. Мод, бутны тогооны хөрс сийрүүлэх 10. Мандлын цэцэг болон зүлэг бордох 11. Зүлэг тайрч тэгшлэх 12. Хог ургамалтай тэмцэх 13. Мод, бут сөөгний тулаас задлах 14. Цэцгийн мандлын усалгаа хийх 15. Мод, бутны өвчин, хортонтой тэмцэх, шохойдох 16. Мод, ургамлыг манах өвөлд бэлтгэх 17. Ногоон байгууламжийн тооллого хийх 18. Мандлын нэг наст цэцгийн талбайг цэвэрлэх 19. Мод, сөөг тарих (арчилгааны зардлын 20 хувьд ногоон массын хэмжээг нэмэгдүүлэх, мод, бут, сөөг, зүлэг нөхөн тарих) 20. Цэцгийн мандал байгуулах 21. Талбайн зүлэгжүүлэлт 22. Мод, бут сөөг бордох 23. Хатуу хучилттай явган хүний зам, талбайг сард 9 удаагийн давтамжтай цэвэрлэх (11206 м.кв) бөгөөд Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан тарифыг мөрдөнө; - Дээрх ажилбараас гадна ногоон байгууламжтай талбайн хамгаалалтын хашаа, хайс, троссон хашлагыг шинэчлэх, засаж сэлбэх, хазайж, муруйсан шонг тэгшлэх, шаардлагатай тохиолдолд шинэчлэх; - Ажлын тоо хэмжээ, талбар дээр хийгдэх ажлын талаар захиалагчтай зөвшилцөх; - Ургалт зогссон болон механик гэмтэл авсан модыг хэмжилт хийж, талбайгаас чөлөөлөх; - Хариуцсан талбайн мод, бут, сөөгийг бүртгэлжүүлэх, тэмдэгжүүлэх,
8	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Улаанбаатар хотын ногоон байгууламжийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй стандартыг мөрдөж, агро технологийн ажилбаруудыг бүрэн тусгаж, эдийн засгийн тооцоо болон төсвийг эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох - Хатуу хучилттай зам талбайн цэвэрлэгээг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан тарифыг мөрдөнө;
9	Улаанбаатар хотын ногоон байгууламжийн үйл	Улаанбаатар хотын тохижилт ногоон байгууламжийн төрийн удирдлагын үйл ажиллагаа:

	ажиллагаанд мөрдөгдөж буй стандарт	1.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа MNS 4969:2000 2.Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага MNS 6139:2010 3.Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага MNS 6141:2010 4.Мод үржүүлгийн газрын хөрсийг боловсруулах, Ерөнхий шаардлага MNS 2418:2011 5. Мод үржүүлгийн газар бордоо хэрэглэх MNS 6252:2011 6. Мод сөөгний үрийг тарихад бэлтгэх, Ерөнхий шаардлага MNS 6253-1:2011 7. Мод сөөгний үр тарих Ерөнхий шаардлага MNS 6253-2:2011 8. Мод сөөгний үр тарьсны дараа арчлах. Ерөнхий шаардлага MNS 6253:2011 9. Мод сөөгний суулгацыг бойжуулах, Ерөнхий шаардлага MNS 6254:2011 10. Сөөгний суулгац. Ерөнхий шаардлага MNS 6255:2011 11. Сөөгөнцөрийн суулгац. Ерөнхий шаардлага MNS 6256:2011 12. Улиасны суулгац. Ерөнхий шаардлага MNS 6257:2011 13. Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах. Ерөнхий шаардлага MNS 6258-1:2011 14. Мод сөөгний суулгац арчлах MNS 6258-2:2011 15. Ганц наст цэцэг тарих арга MNS 6259:2011 16. Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260:2011 17. Тасалгааны олон наст цэцгийг тарих,арчлах MNS 6261:2011 18. Цэцэрлэгжү үлсэн талбайг шалгаж, ашиглалтад хүлээн авах. Ерөнхий шаардлага MNS 6263:2011 19. Улиасны модожсон мөчрийн тайраадас. Ерөнхий шаардлага MNS 1796:2011 20. Бордоо. Доломитын бордоо Техникийн шаардлага MNS 6662:2017 21. Мод сөөгийг хэлбэржүүлэх. Техникийн шаардлага MNS 6772:2019 22. Сөөгний суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах Техникийн шаардлага MNS 6773:2019 23. Том мод, суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах MNS 6774:2019 24. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай хэмжээ MNS5973:2009 25. Голтборын төрлийн ургамлыг тарих, арчлах. Техникийн шаардлага MNS 6863: 2020 26. Мод үржүүлгийн газарт гоёл чимэглэлийн мод, сөөгний суулгац ургуулах Техникийн шаардлага MNS 6864:2020 27. Сарнайн төрлийн ургамлыг тарих, арчлах.Техникийн шаардлага MNS 6862:2020 28. Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260:2020 29. Навчит модны суулгац, техникийн шаардлага MNS 6141:2020 30. Ургамал цуглуулах, тодорхойлох арга MNS 6865:2020 31. Чанарын менежментийн тогтолцоо – Шаардлага: MNS ISO 9001:2006 <u>Ургамал хамгааллын чиглэлээр:</u>

		1. Азот фосфор калийн холимог бордоо, техникийн шаардлага MNS 5891:2008 2. Фосфорын бордоо MNS 4305: 1996 <u>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан ногоон байгууламжийн бүлэгт хамаарах стандарт:</u> 1. UCS0801A:2022 "Хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн төлөвлөлтийн удирдамж 2. UCS0802C:2022 "Мод таримал ургамлын төрөл зүйлийн лавлах" 3. UCS0803B:2022 "Ногоон байгууламжийн арчилгаанд тавигдах шаардлага" 4. UCS0802A:2022 "Цэцэрлэгчийн хөдөлмөр аюулгүй ажиллагааны удирдамж" 5. UCS0801C:2022 "Цэцэрлэгчийн хөдөлмөрийн багаж хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийн лавлах <u>Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт:</u> 1. Баримт бичиг.2-р хэсэг: Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага MNS 5140-2:2021
10	Тайлагналт	Захиалагчаас гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хагас жил, жилийн эцсээр дүгнэж, үр дүнгээс хамааран гэрээг сунгах, цуцлах эрхтэй. Гүйцэтгэгч сар бүр гүйцэтгэлийн тайлан, үнэлгээ, түүнтэй холбогдох баримт бичгийг албан хэрэг хөтлөлтийн стандартыг ханган боловсруулж, холбогдох нэгж, албан тушаалтнаар баталгаажуулж, ирүүлнэ.

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ:

ДҮҮРГИЙН МЕНЕЖЕР Ц.ЭРДЭНЭБААТАР

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД:

ХОТЫН СТАНДАРТ, ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА Г.ТУЯАЦЭЦЭГ

СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБОО ХАРИУЦСАН АЖИЛТАН О.АНХТУЯА

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Т. ОЮУНСҮРЭН

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2026 оны
..1.. дүгээр сарын 28-ны өдрийн 01/1
дугаартай ажлын даалгаврын хавсралт

БАГЦ 1. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН АРЧИЛГАА, НӨХӨН ТАРИЛТЫН АЖЛЫН БАЙРШИЛ, ТОО ХЭМЖЭЭ

№	ГУДАМЖ ТАЛБАЙ, ЦЭЦЭРЛЭГИЙН НЭР	Хариуцах талбайн хэмжээ мод бутны тоо							Цэвэрлэх талбай, м.кв	2026 онд хийх ажлын тоо хэмжээ									
										Шинээр тарих			Нөхөн тарих			Нөхөн тарих зүлэг, м.кв	Тарих цэцгийн тоо, ширхэг	Шинэчлэх	
		Нийт талбай	Зүлэгт талбай, м.кв	Том нарс, гацуур мод	Навчит мод	Бут сөөг	Торхтой мод	Ургамлан хашлага у/м		Мод, ширхэг	Бут сөөг, ширхэг	Ургамлан хашлага, урт метр	Мод, ширхэг	Бут сөөг, ширхэг	Ургамлан хашлага, урт метр			Шон, ширхэг	Тросс, урт метр
БАГЦ - 1. Хан-Уул дүүргийн нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн арчилгаа, нөхөн тарилтын ажил																			
1	Шинэ Хан-Уул цэцэрлэгт хүрээлэн, 22-р байрны зүүн тал (Хан-Уул дүүрэг, 1-р хороо)	20,634	9428	45	267	1452	-	684	11,206	257	577			300		3000	10000		
2	Махатма Гандийн гудамж (Хан-Уул дүүрэг, 15-р хороо)	6740	6,740	169	148	1591		1,420		50	627				150	500	3000		
3	Тев цэнгэлдэх хүрээлэн (Хан-Уул дүүрэг, 15-р хороо)	33606	33,606	149	225	1510		190					30			5000	10000		
Дүн		60,980	49774	363	640	4553		2294	11,206	307	1204		30	300	150	8500	23000		